

БАТЛАВ.
БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



..... Б.БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ТАЛЫН-ЭРДЭС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... Г.ГАН-ЭРДЭНЭ

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМ
ШИРЭН-ОВОО ТӨМРИЙН ХҮДРИЙН ТӨСЛИЙН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НЭР, ДУГААР:

Ширэн-Овоо, MV-020902

АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, РЕГИСТРИЙН ДУГААР:

“Талын-Эрдэс” ХХК, 5857872

Хянасан: Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын
ахлах мэргэжилтэн

Ч.ДАМБАСҮРЭН

Боловсруулсан: “Талын-Эрдэс” ХХК-ийн Байгаль орчны менежер

Б.БАТБАГАНА

Улаанбаатар хот 2023 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн товч тодорхойлолт	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	10
3.1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ	10
3.2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл... 10	
3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл.....	10
3.4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл 10	
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	12
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ.....	17
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
9. ТҮҮХ СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ДУРСГАЛТ ЗҮЙЛС	18
10. ХИМИЙН БОДИС ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	19
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	24
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ СУМ БАГЫН ИРГЭДЭД ТАЙЛАГНАХ АЖЛЫН ХУВААРЬ	25

Хавсралт материал

- 2 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- 3 Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар
- 4 Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан бичиг
- 5 Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тодорхойлолт
- 6 БО-ны кадастрын лавлагаа
- 7 Хайгуулын ажлыг хүлээж авсан ЭБМЗ-ийн дүгнэлт
- 8 ЭБМЗ-ийн ТЭЗҮ хүлээн авсан дүгнэлт
- 9 АМГ-ын даргын ТЭЗҮ хүлээн авсан тушаал
- 10 Батлагдсан ТЭЗҮ-ийн нүүр хуудас
- 11 БОНБНҮ нэлгээний батлагдсан нүүр
- 12 2022 оны уулын ажлын төлөвлөгөөний нүүр хуудас
- 13 Уурхайн план зураг
- 14 2022 оны уулын ажлын төлөвлөгөөний 1.1, 2.1, 6.2, 7.1, 10 маягтууд
- 15 БОМТ-ний Хяналтын хуудас

1. ОРШИЛ


“Талын Эрдэс” ХХК нь Дорнод аймгийн Халхгол сумын нутагт Ширэн-Овоо нэртэй төмрийн хүдрийн орд бүхий 1745,74 га талбайтай MV-020902 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Ширэн-Овоогийн ордыг ашиглалтад оруулж, төмрийн баяжмал, бөөмцөг (агломераци) үйлдвэрлэх үйлдвэрийг уг ордыг түшиглэн байгуулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь Монгол улс дахь металлургийн үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, бүс нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зэрэг олон эерэг талтай хэмээн үзэж “Талын Эрдэс” ХХК-ийн зүгээс уг ордыг ашиглахаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан болно. Үйлдвэрийг байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалт, төсөлтэй холбоотой гарах эрсдэл, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт, маркетингийн хариуцлага зэргийг “Талын Эрдэс” ХХК бүрэн өөртөө хүлээж байгаа болно.

Манай компани Ширэн-Овоо төслийн ТЭЗҮ-г боловсруулж, 2017 онд батлуулсан бөгөөд төслийн хөрөнгө оруулалтын шалтгааны улмаас БОНБНҮ-г 2021 онд хийлгэж, 2022 оны 1-р сард БОАЖЯамаар батлуулсан бөгөөд өмнөх онд ямар нэг үйл ажиллагаа явуулаагүй болно. (Дорнод аймгийн Халхгол сумын Засаг даргын тодорхойлолтыг хавсаргав.)

1.1. Төслийн товч тодорхойлолт

“Талын Эрдэс” ХХК-ийн Ширэн-Овоо нэртэй, MV-020902 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай нь Дорнод аймгийн Халхгол сумын нутагт L-50-35 хавтгайд оршино. Талбайн хэмжээ 1745.74 га. Ширэн-Овоо ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Халхгол сумын төвөөс зүүн урагш 70 км, Буйр нуураас 3.У-160 км, Сүмбэр уулаас зүүн урагш 90 км-т, Ширэн-Овоо уулаас урагш 10 км-т, Сүмбэрийн боомтоос баруун тийш 8 км-т, эдийн засгийн хувьд дэд бүтэц сул дүүрэгт оршино.

Ил уурхайн хүрэн дэх нөөцийг бодитоор тогтоохын тулд, нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн ордын хүдрийн биетүүд болон геологи хайгуулын ажлаар тогтоогдсон нөөцөд тулгуурлан уул уурхайн төлөвлөлтийн программ ашиглан ил уурхайн оновчтой хүрээ хязгаарыг эцэслэн байгуулж, ил уурхайн хүрэн дэх хөрс, хүдрийн хэмжээг түвшин бүрээр тооцоолон гаргалаа. Тооцоогоор ил уурхайн хүрээнд бодитой В зэрэглэлийн нөөц 8522.1 мян.тн хүдэр байна. Харин В зэрэглэлийн нөөцийг ашиглах явцад олборлолтод зайлшгүй өртөх боломжтой С зэрэглэлийн нөөц 1308.6 мян.тн хүдэр ордоос ил аргаар ашиглах нөөц В+С зэрэглэлээр 9830.7 мян.тн хүдэр олборлогдохоор байна. Энэхүү ил уурхайн хүрэн дэх төмрийн хүдрийн нөөцийг ашиглахын тулд ил уурхайгаас нийт 12534.8 мян.м³ хөрс хуулахаар тооцоологдлоо. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр ордын хэмжээнд дунджаар 1.57 м³/тн болж байна.



Зураг 1. Төслийн байршил

1.2. 2023 оны уулын ажлын хэмжээ, ажиллах горим

2023 онд Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн ордод 1137.65 мян.м³ хөрс хуулж, 174.218 мян.м³ хүдэр олборлолтын ажил хийгдэх төлөвлөгөөтэй ажиллана. Нийт 1311.87 мян.м³ уулын цулыг өрөмдлөг тэсэлгээний ажлаар тэслэн сийрэгжүүлэх ажлууд тус тус хийгдэнэ.

Хүснэгт 1. 2023 онд явуулах уулын ажлын хэмжээ

№	Түвшин	Хөрс м ³	Хүдэр м ³	Уулын цул м ³
1	978-986	135031	66977	202008
2	986-994	439600	75388	515010
3	994-1002	368780	257388	394513
4	1002-1010	174354	6120	180474
5	1010-1018	19871	0	19871
	Нийт	1137658	174218	1311876

1.3. Ордын ашиглалтын уул техникийн нөхцөл:

Ширэн-Овоогийн төмрийн хүдрийн ордон ерөнхий суурь усжилт нь нийт талбайн хэмжээнд маш бага, туйлын хязгаарлагдмал учраас ордон олборлох үед уул-технологийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хүндрэлгүй юм. Хүдрийн эзлэхүүн жин нь хайгуулын ажлын нөөцийн тооцоонд тооцогдсоноор 3.7 тн/м³, агуулагч чулуулгийн эзлэхүүн жин 2.65 тн/м³

байхаар тооцон авав.

Уурхайн үйлдвэрлэлийн хэмжээ: 1 жилд

- 1137658 хөрс хуулалт м³
- 644606 хүдэр олборлолт тн

Ажиллах горим:

- уурхай жилд 240 хоног ажиллана
- хөрс хуулалт 240 хоног, 2 ээлж, ээлжийн үргэлжлэл 10 цаг
- хүдэр олборлолт 240 хоног, 2 ээлж, ээлж үргэлжлэл 10 цаг

Бүтэц, зохион байгуулалт: Үйлдвэрийн үйл ажиллагааны амжилт нь нягт цэгцтэй удирдлага зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн бодлого, ажлын шуурхай шинжээс ихээхэн шалтгаална.

Олон тооны цех, хэсэг нэгж бүрийн ажлын өвөрмөц онцлог эдгээрт ажиллаж буй хүмүүсийг үйлдвэрлэлд зохион байгуулах өөр өөр арга барил бүр нь түүнд тохирсон дүрэм журмын үндсэн дээр шийдвэрлэгдэж, шат дараалан үүрэг гүйцэтгэж, ажил явуулах, хариуцлага хүлээх тогтолцоо хэрэгтэй юм. Ийм учраас үйлдвэрийн удирдлагын бүтэц нь нэлээд өвөрмөц, хамтран шийдвэрлэх, зохицон зөвшилцөхөд тохирсон зохион байгуулалттай байна.

Уурхайн гүн:

2023 онд хөрс хуулалтын хэмжээ, хүдэр олборлолтын уялдаа, дараа жилийн нээгдэх хүдэр зэргийг тооцон 978 түвшинд хүртэлх талбайг ашиглахаар ил уурхайг ажиллуулахаар тооцооллоо.

Уурхайн үндсэн хэмжээс:

Дараах үндсэн хэмжээстүүдийг ашиглан ил уурхайнуудын хязгаарыг тооцов.

Үүнд :

- Доголын өндөр 8 м
- Ажлын бус доголын хажуугийн өнцгийг ерөнхийд нь 65⁰ -аар тооцов.
- Уурхайн хажууд байрлах догол хоорондын аюулгүй тавцангийн өргөн 3 м
- Авто замын өргөн 15 м
- Замын налуугийн хэмжээ 8⁰
- Уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн 25 м

1.4. АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, УУЛЫН АЖЛЫН МЕХАНИКЖУУЛАЛТ

1. Ашиглалтын технологи

Ордын хүдрийн биетүүд бүгд босоо уналтай, давхарга, линз хэлбэртэй бөгөөд харьцангуй бага зузаантай байна. Хүдэрийн биет, агуулагч чулуулаг нь бат бөх ба нэлээд бат бөх чулуулагт хамаарна. Техник-эдийн үндэслэлд тооцсоноор тухайн ил уурхайд тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системийг сонгож авлаа.

2. Үйлдвэрлэлийн процессууд, иж бүрэн механикжуулалт


Ил уурхайн хэлбэр хэмжээ (орон зай), чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөлүүдийг үндэслэн дараах технологи, механикжуулалтын бүтцүүд хөрс хуулалт, олборлолтын ажилд тохиромжтой гэж үзэж байна.

Хүснэгт 2. Уулын ажлын процессууд

Ажил	Процессууд / тоног төхөөрөмж			
Хөрс хуулалт	өрөмдлөг тэсэлгээ	Экскаваци	Тээвэрлэлт	Овоолго
	өрмийн машин	Экскаватор	Автосамосвал	Бульдозер
Хүдэр олборлолт	өрөмдлөг тэсэлгээ	Экскаваци	Тээвэрлэлт	Овоолго
	өрмийн машин	Экскаватор	Автосамосвал	Бульдозер

1.5.Хүдрийн баяжуулах технологи

Хүдрийн эрдсээс магнетит зонхилох бөгөөд дунджаар хүдрийн 25-30 орчим хувийг эзлэх ба бусад хүдрийн эрдсүүд нь (пирротин, сфалерит, халькопирит, пирит, висмутин) нь 10-15% ийг эзэлж байна. Энэ хүдэрт үйлдвэрийн ач холбогдолтой эрдэс нь магнетит юм. Магнетитийн дундаж агуулга нь 30 орчим хувь гэж тооцоолов. Тэрээр исэлдээгүй ба мөхлөгийн хэмжээ 0.1-1.5мм байна



Зураг 2. Баяжуулах технологи

1.6.Өрөмдлөгийн ажлын тооцоо

2023 онд Ширэн-Овоо уурхайд 1311.876 мян.м³ уулын цул буюу 96719 уртааш метр өрөмдөх төлөвлөгөөтэй өрөмдлөгийн ажилд 2 ширхэг JK358H өрмийн машин хэрэглэнэ. Өрөмдлөгийн ажил хийхдээ цооногийн торлолыг JK358H өрмийн машин хөрсөнд өрөмдөх үед сетка 4м х 3.46 м, JK358H хүдэрт сетка 3м х 4 м өрөмдөж байхаар тооцно.

Хүснэгт 3. Өрөмдлөгийн ажлын тооцоо

№	Түвшин	Хөрс /м ³ /	Хүдэр /м ³	Уулын цул /м ³ /	Хөрс		Хүдэр	
					Уртааш	Цооногий н	Уртааш ш	Цооногий н
1	978-986	135031	66977	202008	9757	1220	5581	698
2	986-994	439622	75388	515010	31765	3971	6282	785
3	994-1002	368780	25733	394513	26646	3331	2144	268
4	1002-1010	174354	6120	180474	12598	1575	510	64
5	1010-1018	19871	0	19871	1436	179	0	0
Нийт		1137658	174218	1311876	82201	10275	14518	1815

Хүснэгт 4. Тэсрэх материалын зарцуулалт

№	Түвшин	Хүдэр /м ³ /	Хөрс/м ³	Нийт өрөмдөгдөх цооногийн тоо	Уртааш метр/м/	Нэг цооногт орох тэсрэх бодисын хэмжээ,		Нийт хэрэглэгдэх тэсрэх бодисын хэмжээ, кг	
						Хүдэр	Хөрс	Хүдэр	Хөрс
1	978-986	66977	135031	1917	15338	172.8	88.576	120559	108025
2	986-994	75388	439622	4756	38047	172.8	88.576	135698	351698
3	994-1002	25733	368780	3599	28790	172.8	88.576	46319	295024
4	1002-1010	6120	174354	1638	13108	172.8	88.576	11016	139483
5	1010-1018	0	19871	179	1436	0	88.576	0	15897
Нийт		978229	10782440	43695	4336			3592	910126

Тэсэлгээний ажлын зохион байгуулалт, аюулгүй ажиллагаа: Тэсэлгээний ажлын паспорт: Энэхүү төсөлд өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх үед мөрдөх жишиг паспортыг хавсаргав. Тэсэлгээний ажлын зохион байгуулалт, тухай бүрийн тэсэлгээний ажлын үйлдэл, паспортыг энэ ажлыг хариуцсан инженер төсөл зургийн дагуу тухайн нөхцөлд тохируулан нарийвчлан боловсруулж тэсэлгээчдэд танилцуулан мөрдөж ажиллана.

Тэсэлгээний ажлын хяналт: Ширэн-Овоо төмрийн ордод хийгдэх тэсэлгээний ажлыг аюулгүй ажиллагааны нөхцөлийг ханган зохион байгуулж, технологийн болон тухайн тэсэлгээний паспортын мөрдөлт, тэсэлгээний ажил гүйцэтгэх эрх эзэмшигч байгууллагын тавьсан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавина. Энэ ордын тэсэлгээний ажлыг гүйцэтгэх үедээ “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэглэлийн эргэлтэд хяналт тавих тухай” Монгол улсын хууль болон “Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу тэсрэх материал ашиглах үйл ажиллагааг зохион байгуулна.

Шимт хөрсний овоолго

Уулын ажлын ба байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу олборлолтын талбайгаас өнгөн хөрс-ургамлын үеийг шилжүүлэн хадгалах зорилгоор тусгайлан бэлдсэн талбайд зөөж цаашдаа талбайн нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэнэ. Шимт хөрс овоолох талбай нь 1.5 га бөгөөд 64595.3 м³ шимт хөрсийг 5м-ээс доошгүй овоолго үүсгэн хэлбэршүүлэн хадгална.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй: Талбай орчмын газар нутгийн уулс, толгодууд нь Хянганы нурууныбаруун салбар, харьцангуй нам хэсэг нь болох ба дундаж өндөр нь далайн түвшнээс дээш 1100-1200 м, бөмбөгөр оройтой бэсрэг уулс зонхилно. Талбайн хамгийн өндөр цэг нь Туулайтын өндөр уул (1071.9 м), хамгийн нам цэг нь талбайн баруун захын хөндийд байрлана. Баруун хавцгайтын ам (821.0 м) юм.

Талбай орчмын талбай нь нэлэнхийдээ уулархаг, толгодлог рельефтэй, хүрмэн чулуу бүхий голын эгц, өндөр эрэг Нөмрөг голын дагуу хөгжсөн, энэ хэсэгт Түмэн (1066.0 м), Туулайтын Өндөр (1071.9 м), Хавирга (1124.2 м) зэрэг уултай, голчлон 980- 1100 м өндөр бэсрэг уулстай, уулс нь модлог, бут сөөг ихтэй, Нөмрөгийн голын зүүн гар талын цутгалуудын хөндийнүүд нь нарийхан байдаг.

Ус зүй: Буйр нуур-Халх голын сав газар дахь газрын доорх усны сав нь Монгол Улс, БНХАУ-ын нутаг дээр тус 2 улсын хилийн нутгийг дамнан байрладаг бөгөөд Монгол Улсын нутгийн дотор уг савд талбайтай хамгийн ойр оршдог нь дэгээ гол юм. Хавтгай Өндөр уулаас эх аван Нөмрөгийн ДЦГ-ын хилийн гадна талаар зүүн хойш чиглэлтэйгээр 42 км орчим урсан Халх голд цутгадаг. Дэгээ гол нь 550 хавтгай дөрвөлжин километр талбайгаас усжих ба 55 километр урт юм. Голын хөндийд намаг ихээхэн тогтсон. Урсгалын хурд 0,6-0,7 м/сек байна.

Уур амьсгал: Төслийн талбай нь уур амьсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд дорнод хэсгийн хүйтэн өвөлтэй хуурай эх газарзүй мужид хамаарагддаг.

Жилийн дундаж температурын хэлбэлзэл -23.7 хэмээс +21.8 хэм байдаг. Хамгийн хүйтэн сар нь нэгдүгээр сар ба -31 хэмээс -35 хэм хүртэл хүйтэрдэг. Жилийн хамгийн дулаан сар нь 7 дугаар сар бөгөөд + 20-оос + 25 хэм хүрдэг.

Жилд унах дундаж хур тунадасны хэмжээ 200-300 мм ба эдгээрийн зонхилох хувь нь зуны улиралд унах ба өвөлдөө уулархаг хэсгээр нэлээд цас унадаг. Цасан бүрхүүлийн зузаан 3-5 см, хамгийн их нь 15-20 см хүрэх ба 10 дугаар сараас 5 дугаар сар хүртэл цастай байна.

Зам харилцаа: Халх гол сум нь Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос 370 км, Улаанбаатар хотоос 870 км зайд оршино. Улаанбаатар хотоос Дорнод аймгийн Чойбалсан хот хүртэл засмал замтай. Аймгийн төвтэй холбосон гол зам нь шороон зам учир бэрхшээл ихтэй. Энэ үзүүлэлтийг тооцож үзвэл аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хязгаарлагдмал байна. Зуны улиралд ирэх жуулчдын тоо бусад газартай харьцуулахад хязгаарлагдмал гол төлөв сонирхлын аялал жуулчлал хөгжсөн гэж тооцож болно. Зам харилцааны ачаалал бага, өдөрт 10-20 машины ачаалалтай байна.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1.Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл, бууруулах арга хэмжээ

2023 онд уулын ажлын хөрс хуулалт, хүдэр олборлолт, овоолго, тээвэрлэлтийн үед тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар байна. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.

3.2.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон химийн бохирдолд орох эрсдэлтэй.

3.3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2023 онд уурхайн хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно. Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Ил уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсэж тоосжилт үүсгэнэ. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдоно.

3.4.Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын үед ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, машин механизм, тээврийн хэрэгслийн гэрэлтүүлгээс болж шөнийн амьдралтай амьтад үргэн дайжиж болзошгүй.

3.5.Нөхөн сэргээж буй газрыг хүн мал, салхи, усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхайн эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж дууссан газрыг бусад хүчин зүйлээс болж буцаж эвдэрч, доройтохоос хамгаалахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1. Хүн малын нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газарт мал орох, болон санаатайгаар малаа хариулах, тарьсан мод, бутыг хэрэглэх, машин техникээр дээгүүр нь явах, ахуйн зорилгоор ухаж сэндийлэх зэрэг хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай бөгөөд энд орон нутгийн захиргаа болон нутгийн иргэдийн ухамсарт оролцоо маш чухал үүрэгтэй байна.

2. Усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Нөхөн сэргээлт хийсэн газар нь хэвгий, налуу ихтэй хөрсний бүтэц султай болон бүтэцгүй тохиолдолд хөрс усаар угаагдаж, алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Ийм газарт ургамлын тарих эгнээг налуугийн эсрэг чиглэлд хийх, шигүү тарих, сахлаг үндэстэй ургамал тарих зэрэг арга хэмжээг авна.

3. Салхины нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах

Уурхай орчмын нутаг нь хуурай хээрийн бүсэд хамаарах газар учраас жилд тохиолдох хүчтэй салхи шуурганы давтамж өндөр байдаг. Иймээс биологийн нөхөн сэргээлт хийсэн газрыг салхины эвдрэл болон элсний нүүлтээс хамгаалах арга хэмжээг зайлшгүй шаардлагатай. Энд салхины зонхилох чиглэлд хөндлөн байдлаар бут сөөг модлог ургамал оролцсон зурвас байгуулах, төрөл бүрийн механик хамгаалалт хийх шаардлагатай.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Тоосжилт болон агаар бохирдуулагч хийнүүдийн хэмжилт судалгааг хийж, хяналт тавих. Стандарт шаардлагад заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй байх арга хэмжээ авна,
- Хөрс хуулж овоолго хийх ажлыг аль болох цөөн хоногт багтаахаар зохион байгуулна,
- Тоосжилт тархах хүрээ ачиж, тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчимд байхаар зам, овоолгын байршлыг оновчтой сонгох, улмаар байнгын ажлын байрнаас зайдуу байршуулна,
- Уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замуудыг тоосжилт ихтэй үед байнга усалж байх,
- Төслийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх зорилгоор тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд хяналт тавина,
- Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ,
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийнэ,
- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлнэ,
- Уурхайн үйл ажиллагааны явцад боломжтой газруудад нөхөн сэргээлтийг дор дор нь хийж байх,
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулах, шимт хөрсийг аль болох богино хугацаанд нөхөн сэргээлтэд ашиглах
- Ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Тосгон ба ордыг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах
- Тоног төхөөрөмжийн шатах тослох материалын төвлөрсөн цэгийг байгуулж, нэвчүүлэхгүй материал ашиглан тохижуулах
- Талбайн хэмжээнд байрлах уст цэгүүдэд тогтмол горимын болон чанарын хяналт шинжилгээг явуулах
- Шатах тослох материал, алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах зэрэг арга хэмжээг авч ажиллана

Шимт хөрс хадгалах хамгаалах талаар

Хөрс хуулалтын өмнө тухайн талбайг цэвэрлэж, техник хэрэгслийг саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Хуулсан шимт хөрсийг дээрх стандарт шаардлагуудад заасны дагуу нөхөн сэргээлтэд ашиглах хүртлээ тусгай талбайд овоолж хадгалах ба ингэхдээ дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу болон бусад хаягдалд дарагдан бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
2. Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын гадна талаар салхи, борооны элэгдлээс хамгаалах хамгаалалт хийх, овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлэн олон наст өвслөг ургамал тариалах
3. Шимт хөрсний овоолгын байршил, хэлбэр хэмжээ нь түүний хамгийн сайн хадгалагдах нөхцөлийг хангасан байх шаардлагатай ба шимт хөрсний овоолгын өндөр нь 5 м-ээс илүүгүй байх

Шимт хөрсний хадгалалт, хамгаалалт, тордолтын бүртгэл, хяналтын ажлыг зохион байгуулах, тогтмолжуулах

Уурхайн тоосжилттой тэмцэх арга хэмжээ

- Ухаж ачих процессын үед үүсэх тоосны хэмжээг бууруулах зорилгоор авто замыг байнга услах, замын материалыг оновчтой сонгох.
- Олон салаа зам гаргахаас сэргийлж уурхайн дотоод ба гадаад авто замын сүлжээг оновчтой төлөвлөх.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2023 онд хийгдэх нөхөн сэргээлтийн ажил.

2023 онд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй. Харин шимт хөрсний овоолгыг 1.5 га газарт стандартын дагуу овоолго хийж хадгална.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудыг мөрдөж ажиллах;
- Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаалах;
- Цаашид ашиглах шаардлагагүй хөндөгдсөн талбайнуудыг тухай бүрт нөхөн сэргээж, орон нутагт хүлээлгэж өгөх;
- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, компанийн чадамжийн хэмжээнд хувь нэмрээ оруулах;
- Батлагдсан БОМТ 2023-г хамгийн багадаа 90%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэх;
- Хүрээлэн буй орчны талаар ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх;
- Байгаль орчны мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;
- Төрийн захиргааны байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хяналт шалгалт, БО-ны аудитаас гарах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, засгийн газар, БОАЖЯ болон бусад холбогдох газруудаас гаргасан зохих заавар, журмын дагуу “ТАЛЫН ЭРДЭС” ХХК-ийн “Ширэн-Овоо”-ийн төмрийн хүдрийн ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

Төсөл хэрэгжүүлэгч “ТАЛЫН ЭРДЭС” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагааны сөрөг нөлөөллөө байгальд үзүүлж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлнэ.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	9
1	Агаарын чанар	1. Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд утааны шүүлтүүрүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тос, малыг тогтоосон хугацаанд нь сольж, битүүмжилсэн агуулах, саванд бүртгэлжүүлэн хадгална.	Уурхайн хэмжээнд	Мот/цаг	Уулын ажлын төсөвт орсон	Улирал бүр	- Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль - MNS 4585:2016 MNS 3384:82 - Агаарын тухай хууль
		2. Уурхайн замын сүлжээг оновчтой төлөвлөн батлан мөрдүүлж, тоосжилт ихтэй үед замуудыг услах	Уурхайн хүрээнд	-	6,500,000	Тухай бүрт	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
		3. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	Уулын ажилд хамрагдах тээврийн хэрэгслүүд байна.	-	Уулын ажлын төсөвт орсон	Жил бүр	MNS 4885:2007 Агаарын тухай хууль
	Нийт						
2.	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд тусгагдсан дагуу усны нөөцийн судалгаа хийлгэн, уурхайд ашиглах гүний худаг гаргаж, тоолууржуулна					Усны тухай хууль MNS 900:2005 MNS 4943:2015 MNS 5850:2008
		Уурхайн ахуйн шингэн хаягдлыг байгаль орчинд ээлтэй, ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулна					

		Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Төслийн хүрээнд		Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд		
		Уурхайгаа тойруулан үерийн далан байгуулах	Үйл ажиллагааны зардалд орно			Төслийн хугацаанд		
		Унд ахуйн усанд эрүүл ахуй болон хамгаалалтын бүсийг тогтоож бүсэд мөрдөх журмыг сахиж ажиллана.			1,000,000			
		Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уст цэгт		Зардал нь хяналт шинжилгээний зардалд орсон	Төслийн хугацаанд		
	Нийт						1,000,000	
3.	Газрын хэвлий болон Хөрсөн бүрхэвч	Газар эзэмших гэрээгээ сумын Засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Уурхайн хэмжээнд	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	MNS 5916:2008 MNS 5917:2008 MNS 5918:2008	
		Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг элс асгаж саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна. Засвар үйлчилгээний талбайг хатуу хучилттай болгож, ашиглана	Засварын талбай, авто зогсоол	-	1,000,000	Төслийн хугацаанд		
		Хог хаях, шатах тослох материал асгах, хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх, олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Уурхайн хэмжээнд	-	1,500,000			
	Нийт						2,500,000	
4	Ургамлан нөмрөг болон Амьтны аймаг	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн зам, уурхайн хил хязгаар	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль - Байгаль орчныг хамгаалах тухай MNS 5916:2008 MNS 5917:2008	
		Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна.	Уурхайн хотхонд	-	1,500,000	Төслийн хугацаанд		

		Уурхайн нөхөн сэргээлтэд зориулж үр бэлтгэх зорилгоор нутгийн иргэдэд “Үр бэлтгэх хадгалах, тарималжуулах” сэдвээр сургалт зохион байгуулна.	-	-	Дотоод үйл ажиллагааны зардалд	Жил бүр	MNS 5918:2008
		Уурхайн дотоод болон гадаад тээврийн замын дагуу шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Уурхайн зам, уурхайн хил хязгаар		1,000,000	Жил бүр	
		Автомашинны зогсоолыг хайргаар хучих	Засварын талбай, зогсоол		1,000,000	2022	
		Шимт хөрсний овоолго үүсгэж, ургамалжуулж хадгалах	Уурхайн хэмжээнд		2,000,000	2022	
		Орд орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгааг сумын байгаль хамгаалагчтай хамтарч хийх	-	-	500,000	Жил бүр	
		Орд орчмын амьтны зүйлийн бүрдэл, тархцын судалгааг сумын байгаль хамгаалагчтай хамтарч хийх	-	-	500,000	Жил	
	Нийт						6,500,000
5	Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал				16,500,000.00		

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус уурхай нь 2023-2027 он хүртэлх 5 жилийн хугацаанд нөхөн сэргээлтийн хүрээнд зөвхөн шимт хөрсний нөөц бий болгох, одоогийн шимт хөрсний чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх бөгөөд нөхөн сэргээлтийн ажил 2028 оноос эхлэхээр ТЭЗҮ болон БОННУ-нд тусгагдсан болно.

2023 онд уурхайн талбайд түр ашиглаж хөндөгдсөн бөгөөд цаашид ашиглах шаардлагагүй газруудыг тухай бүрт нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгнө.

7. БИОЛОГИЙ НОЛОН ЯНЗ БАЙДАЛ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

“Талын эрдэс” ХХК нь дүйцүүлэн хамгаалах ажлаар БОННУ-ний тайланд тусгагдсан Дорнод аймгийн Халх гол сумын зүүн урд хэсэгт орших үлдэгдэл нарсан ойг залуу нарсаар нөхөн сэргээх.

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Мэргэжлийн байгууллагаар дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, батлуулна		Төслийн хүрээнд	1 удаа		5,000,000	2022 онд	Аймгийн БОАЖГ-ын 2022 оны 179 тоот албан бичиг
	Халх гол сумын зүүн урд хэсэгт орших үлдэгдэл нарсан ойг залуу нарсаар нөхөн сэргээх	“Тэрбум мод” аяны хүрээнд уурхайн хэмжээнд мод үржүүлгийн бааз байгуулах	Төслийн талбайд	Иж бүрэн 1 хүлэмж, 10000 суулгац	-	5,000,000	2022 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
	Нийт					10,000,000		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд айл өрх, өвөлжөө хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэх шилжүүлэх ажил хийгдэхгүй болно.

9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Талын эрдэс” ХХК-ийн “Ширэн-Овоо” төмрийн хүдрийн ордын талбай түүний ойр орчимд археологийн хүрээлэн болон палеонтологийн хүрээлэнгээр авран хамгаалах хайгуулын судалгааг хийлгэсэн бөгөөд ашиглалтад ямар нэгэн дурсгалт зүйл өртөхгүй. Шинээр түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ажлаа зогсоож энэ тухай Халхгол сумын ЗДТГ, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Сургалт сурталчилгааны зардалд 500,000 төгрөг төсөвлөсөн.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Аюултай бодис асгарах, хяналтаас гадуурх дэлбэрэлт, хүний эрүүл мэнд муудах	Химийн бодисын осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, мөрдөж ажиллана	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	4 шалгалт	10,000	120,000	Сар бүр	Жилийн эцсийн тайланд тусгана	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам,
	Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, хэрэглээнд хөндлөнгийн хяналт тавина								
2.	Гал түймэр, нуралт, техникийн осол, үер, дэлбэрэлт	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах бэлэн байдлыг хангана.	Төслийн үйл ажиллагааны хүрээнд	1 төлөвлөгөө	50,000	50,000	Жилийн эхний сард	Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүлэхуйн тухай хууль
3.		Болзошгүй аюул ослын үед нөхцөл байдлыг холбогдох байгууллагад тогтмол мэдээлнэ	Төслийн хүрээнд	Тодорхойлох боломжгүй	-	-	Жилийн турш		
		Нийт				170,000			

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), техникт ашигласан хаягдал тосны хаягдал зэргээс бүрдэж байна.

Тэдгээр хатуу, шингэн хаягдлыг хадгалах, зайлуулах тус бүлэг тусгасан болно. Хог хаягдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчинд дам үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн болно.

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	7	8	9
1	Ахуйн	Хог хаягдлын түр цэгийн байршлыг сумын Засаг даргаар тогтоолгон, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллана			
		Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	1,000,000		Хог хаягдлын тухай хууль 4-р зүйл, 5-р зүйл 9-р зүйл, 11-р зүйл, 12-р зүйл, 13-р зүйл, 14-р зүйл, 16-р зүйл, 18-р зүйл, 19-р зүйл, 20-р зүйл, 21 -р зүйл, 23-р зүйл, 24-р зүйл Жилд 2 удаа
		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж түр хадгалах зориулалтын хогийн бункер байрлуулах	200,000		
		Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг сумын төвд 2-догч түүхий эд авах цэгт тушаах	-	2022	
		Дугуй, модны хаягдлыг дахин ашиглах, орон нутгийн хэрэгцээнд өгөх	-	Сард 1 удаа	
		Автомашинны сэлбэг, төмрийн хаягдлыг мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх	-		
		Цаас, цаасны хаягдлыг цаас боловсруулах үйлдвэрт тушаах	-	Тухай бүрт нь	
2	Аюултай	Аккумулятор, тос маслын шүүр зэргийг бүртгэлжүүлэн агуулахад хадгалж, аюултай хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ			
		Шатах тослох материалаар хөрс бохирдсон тохиолдолд асгаралтыг цэвэрлэж, саармагжуулах	2,500,000		
		Ажилласан тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулж зохих газарт нийлүүлэх	3,000,000		
		Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Гэрээ байгуулах	7 хоногт 1 удаа	
Нийт			6,700,000		

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхой хугацааны давтамжтай хянах, тайлагнах, бууруулах, арилгах арга хэмжээ авахад тус хөтөлбөрийн зорилго оршино.

Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон төслийн үйл ажиллагаанд дараах үндсэн ач холбогдолтой. Үүнд:

- Байнгын хяналт шинжилгээ хийснээр төслөөс орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тухай бүрд эрт илрүүлэх
- Тухайн илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хийлгэн төр захиргааны байгууллагууд болон төсөл хэрэгжих орон нутгийн оршин суугч, иргэдэд танилцуулж байх нь төслийн цаашид тогтмол хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх юм.

2022 онд хэрэгжүүлэх хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Агаарын чанарын хяналт шинжилгээ, Гадаргын болон гүний усны хяналт-шинжилгээ, Хөрсний хяналт шинжилгээ, ундны ахуйн усны чанарын хяналт зэргээр явуулахаа төлөвлөгдөж байна. Энэ жилийн хяналт шинжилгээний хөтөлбөрийн зорилго байгаль орчинд бохирдол нөлөөлөл байгаа эсэхийг тогтоох, шинжилгээний үр дүн стандартын түвшинд байгааг тогтооход оршино.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаар	Засварын талбай ажилчдын хотхон, уурхай, уурхайн зам	6, 9 -р сард	4 цэгт 2 удаа	100,000	800,000	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ , SO ₂ CO -ын агууламж, Хүнд металл тодорхойлох, Агаар орчны бохирдол агаар дахь цацраг, дуу чимээ, агаарын харьцангуй чийгшил	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063:2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
	Хөрс	Ахуйн бохир усны хаягдал орчимд, шимт хөрсний овоолго, засварын газар, эрүүл талбай	6, 9-р сард	4 цэгт 2 удаа	65,000	520,000	Хөрсний агрохими, нийт азот, фосфор, кали, карбонат, Хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
	Ус	Унд ахуйн ус, гол	6, 9 -р сард	3 цэгт 2 удаа	200,000	1,200,000	Усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (pH, EC, TDS, нийт	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын

						шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , CO ₃ , HCO ₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактериологийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар)	зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/А/171 тоот тушаалын 2-р хавсралт.
	Нийт				2,520,000		

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж ажиллана.

Хүснэгт 8. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв Төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			3	4	5	
	1	2				6
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдүүлнэ	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн хугацаанд			Уурхайн дарга
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сургалчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах.	1,000,000	7 р сард			Уурхайн дарга
3.	БОМТ-ний тайланг хэвлэмэл болон файл хэлбэрээр аймгийн БОАЖГ-азар, аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүдэд өгнө	-	11-р сар			“Талын эрдэс” ХХК-ийн удирдлагууд
4.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих	-	Сар бүр			“Талын эрдэс” ХХК-ийн удирдлагууд
	Нийт	1,000,000				

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төгрөг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүд	Уурхайн үйл ажиллагаатай сум орон нутгийн иргэдийн төлөөлөл, ЗДТГ-ын БО-ны мэргэжилтнүүдийг газар дээр нь танилцуулна.		9-р сард	Дотоод үйл ажиллагааны зардалд	Компанийн байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал зохион байгуулна.	
2		Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулан аймгийн БОАЖГазарт хүргүүлж, төслийн талбайд хийсэн ажлуудыг танилцуулна.		11 сарын 1-нд багтаан			
3		Аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулагдсан нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авах ажлын хэсэгт, актаар хүлээлгэн өгнө		Жил бүр			
	Нийт	Дотоод үйл ажиллагааны зардалд орсон.					

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Хүснэгт 10. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

Д.д	Зардлын утга	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	16,500.0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	10,000.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	6,700.0
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	170.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,520.0
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1,000.0
10	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах	-
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		37,390.0

2023 оны БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт төсөв **37,390,000.00** төгрөг болж байгаа бөгөөд үүний **50% нь 18,695,000.00** төгрөг болж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.